

МОНГО УГААХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ БАНК, САНХМОНГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

Д.Гэрэлбаатар

Удирдлагын академийн Цагдаагийн удирдлага,
стратегийн профессорын багийн ахлах багш. доктор,
цагдаагийн хурандаа

Товч агуулга: Энэхүү нийтлэлд монго угаах гэмт хэрэгтэй тэмцэх Монгол Улсын хууль, олон улсын эрх зүйн орчин, банк санхмнгийн болон хууль сахиулах байгууллагын хамтын ажиллагаа, олон туршлагын талаар судлан үүрийн санал дүгнэлтийг дэвшүүлэн гаргахыг зорилоо.

Толхирол: Монго угаах, Палермогийн конвенц, терроризмыг санхмнжлэх, гэмт хэргээс олсон монго, орлого, бохир монго угаах, эрчимтэй хяналт.

Оршил

Индэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НБ-ын конвенцид монго угаах (money laundering) үйлдлийг: а) тухайн эд хөрөнгө нь гэмт хэргийн орлого гэдгийг мэдсээр байж эд хөрөнгийн хууль бус мсвэрийг нуух, далдлах, хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор эд хөрөнгийг үрчлэх буюу шилжүүлэх; б) тухайн эд хөрөнгө гэмт хэргийн орлого гэдгийг мэдсээр байж эд хөрөнгийн бодит шинж чанар, эх мсвэр, байршил, захиран зарцуулах арга, шилжүүлэх, эзэмшигч буюу эд хөрөнгийн эрхийг нуух буюу далдлах; в) тухайн эд хөрөнгийг олж авах үед түүнийг гэмт хэргийн улмаас олсон орлого гэдгийг мэдсээр байж эд хөрөнгийг олж авах, эзэмших буюу ашиглах; г) монго угаах гэмт хэргийг үйлдэхэд оролцох, хамтрах, үгсэн тохиролцох, үйлдэхийг завдах болон хамжих, хатгах, туслах болон зөвлөгөө өгөх гэж тодорхойлсон.

Манай улс Терроризмыг санхмнжлэхийг хориглох тухай олон улсын конвенцид 2003 онд нэгдэн орсноор олон улсад хөллөн зөвшөөрөгдсөн монго угаах болон терроризмыг санхмнжлэхтэй тэмцэх индэсний тогтолцоотой болохын тулд олон улсын стандартыг дагаж мөрдөх шаардлага зүй ёсоор тавигдсан. Монго угаах болон терроризмыг санхмнжлэхтэй тэмцэх тухай хууль 2006 онд батлагдан улмаар Монголбанкны бтцэд Financial intelligence Unit буюу Санхмнгийн мэдээллийн албыг байгуулж монго угаах болон терроризмыг санхмнжлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны суурийг тавьсан.

ИДСЭН ХЭСЭГ. "Монго угаах гэмт хэргийг Монгол улсын Эрмгийн хуулийн тусгай ангийн 18.6 дугаар зүйлийн 18.6.1 дэх хэсэгт Тэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, монго, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан эзэмшсэн, ашигласан, түүний хууль бус эх мсвэрийг нуун далдлах гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор үрчилсөн, шилжүүлсэн, түүний бодит шинж чанар, эх мсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсан бол..." гэж заажээ.

Харин монго угаах, терроризмыг санхмнжлэх санхмнжлэхтэй тэмцэх тухай, хуулийн 3.1.1 дэх хэсэгт "Монго угаах" гэж гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, монго, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласныг, эсхүл түүний

хууль бус эх мөхсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор мөрдчилсэн, шилжүүлснийг, эсхүл түүний бодит шинж чанар, эх мөхсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсныг" гэж хуульчилсан.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухайн хуульд:

1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсэгт "Тагнуулын байгууллага мөрсдийг илрүүлсэн Эрүүгийн хуулийн 18.6 Мөнгө угаах/ дугаар зүйлд заасан" гэмт хэрэгт.

2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 2. 2 дахь хэсэгт "Эрүүгийн хуулийн Хорин хоёрдугаар бүлэгт заасан авлигын гэмт хэргийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад илрүүлсэн Эрүүгийн хуулийн 18.6 /Мөнгө угаах/ дугаар зүйлд заасан" гэмт хэрэгт.

3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт "Цагдаагийн байгууллага нь энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт зааснаас бусад гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулна" гэж тус тус заажээ.

Дээрх заалт нь Тагнуулын байгууллагын мөрсдийг илрүүлээгүй, Авлигатай тэмцэх байгууллагын авлигын гэмт хэргийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад илрүүлээгүй "Мөнгө угаах" гэмт хэргийг цагдаагийн байгууллага шалгахад тусгасан заалт юм.

Гадны улс орнуудын туршлагаас харахад банкны мөнгөний урсгалд хуулийн болон санхүүгийн хяналтын байгууллагын зүгээс хатуу хяналт тавих шаардлагатайг харуулж байна. АНУ-д холбооны хуулийн болон төрийн санхүүгийн хяналтын байгууллагуудын зүгээс санхүүгийн урсгалд тавих хяналт дэлхийд хамгийн хатуу чангад тооцогдоно. Банкны хууль тогтоомжид тавигдах хяналт зөвхөн Холбооны нэгдлийн тогтолцоонд биш, мөн Сангийн яам, Төрийн Департамент, Худалдааны яам болон АНУ-ын Хадгаламжийн даатгалын Холбооны корпораци зэргийг багтаасан бэхлэлт бүтэн байгууллагуудад ногдож байна. Зээлийн байгууллага болон холбооны хуулийн байгууллагуудын мэдээллийн хамтын ажиллагааны АНУ-ын холбооны хуулиудаас хоёр хуулийг онцгойлон авч үзэж болно. Үүнд: Олон улсын үйл ажиллагааны талаарх банкны тайлан ба тэмдэглэлийн тухай хууль (The Bank Records and Foreign Transaction Reporting Act), мөн төмөрчлөн "Bank Secrecy Act" - BSA гэж нэрлэгдэх (Банкны нууцын тухай хууль) ба Мөнгө угаахтай тэмцэх тухай хууль (1986) зэргийг дурьдаж болно. Эдгээр эрх зүйн хэм хэмжээ батлагдан гарах шалтгаан нь банкны нууцлалыг хадгалах талаар тулгарсан асуудлыг даван туулахад хуулийн байгууллагуудад туслах зорилготой юм.

Эдгээр хэм хэмжээнүүдийн тусламжтайгаар хууль сахиулах болон төрийн санхүүгийн хяналтын байгууллагууд мөрсдийн мэдэлд байнга баяжигдаж, нөхцөл сэргээгдэж байдаг аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг субъектууд болон хувь хүмүүсийн санхүүгийн үйл ажиллагааны тухай ил мэдээллийн сантай болох боломж олж авсан юм. Жишээ нь:

"Bank Secrecy Act" (Банкны нууцын тухай хууль) нь хувь хүмүүс, банк болон санхүүгийн бусад байгууллагын баримт бичгийн бүрдүлэлт, тайлантай холбоотой хэм хэмжээнүүдийг тогтоож үгчээ. Тухайн актын шаардлагын дагуу банкууд болон санхүүгийн бусад байгууллагууд нь тодорхой баримт бичгийг таван жил хүртэл хугацаанд хадгалах, үүр дээрээ байлгах үүрэг хүлээсэн юм. Энэхүү хууль нь улсаас

гарч, орж байгаа болон эсхүл санхүүгийн байгууллагад хадгалагдаж байгаа америк валют болон бусад мөнгөн хэрэгслүүдийн эх үүсвэр, багтаамж, хөдөлгөөнийг тогтооход туслах, мөн төлнөлэн олж авсан мэдээллийг эрүүгийн хэрэг, татварын болон эрх зүйн бусад зөрчлийг мөрдөн шалгахад ашиглах харилцааг зохицуулна.

Хуулийн шаардлагын дагуу хувь хэмжээ, банк болон санхүүгийн бусад байгууллагууд гадаад дотоодын тодорхой үйл ажилагааны тухай тайлагнах үүрэг хүлээнэ. Эдгээр үйл ажиллагаанд:

> Нийт үнийн дүн нь 10 мянган америк доллартай тэнцэх мөнгөн хэрэгсэлийг гадагш гаргах болон оруулж ирэх, мөн төлнөлэн америкийн банкууд болон санхүүгийн бусад байгууллагад дээрхитэй адил хэмжээний мөнгийг данснаас авах болон хийхдээ "A Report of International Transportation of Currency or Monetary Instruments" - CMIR (Валют болон мөнгөн хэрэгсэлийн олон улсын шилжүүлгийн тухай тайлан)-ийн тусгай маягтаар гаальд мэдүүлэх.

> Улсын дотор банк болон санхүүгийн бусад байгууллагад 10 мянган долларын үнийн дүнгээс илүү мөнгийг солих, авах, хадгалуулах буюу шилжүүлэхэд Internal Revenue Service - IRS (Дотоод орлогын алба-америкийн татварын цагдаа)-д "A Currency Transaction Report" - CTR (Валютын гүйлгээний тайлан) гэж нэрлэгдэх тусгай маягтаар мэдүүлэх.

> Үүр улсад 10 мянган доллараас илүү багтаамжтай үнэт цаас буюу дансанд хяналт тавьж байгаа этгээд болон банкад гарын нэсг зурах эрхтэй удирдах ажилтан нь хуанлийн нэг жилийн хугацаанд Холбооны үнэт цаасны газарт "A Report of Foreign Bank and Financial Account" - FBAR (Гадаад банкад байгаа санхүүгийн тооцооны тухай тайлан) гаргаж үлгэх ёстой.

> 1986 оноос эхлэн жижиглэн худалдаалах байгууллага болон хувь хүмүүс "Reports of Cash Payments over \$ 10, 000 Received in a Trade or Business /IRS Form 8300/ (Худалдаа, бизнесээс олсон 10 мянган доллараас илүү бэлэн төлбөрийн тухай тайлан) маягтыг бүлгэмж түүнийг IRS (Дотоод орлогын алба)-д шилжүүлэх үүрэгтэй.

Эдгээр мэдээллийг гаргаж үлгэх зайлсхийсэн хувь хүн, байгууллага нь эрүүгийн болон иргэний эрх зүйн хариуцлага хүлээж, тухайн үйл ажиллагаанаас олсон орлогыг хураах хүртэл арга хэмжээ авдаг байна.

АНУ-д 1986 онд баталж, 1992,1994,1995 болон 1996 онд нэмэлт үүрчлөлт оруулсан "Мөнгө угаахтай тэмцэх тухай" хууль мөн. Энэ хуулийн зорилго нь санхүүгийн урсгалд тавьж байгаа хяналтын дэд бүтцийн (инфраструктур) нэг чухал элемент болох санхүүгийн төрийн хяналтыг сайжруулах талаар зарим нэмэлт арга хэмжээг авч байнга боловсронгуй болгон хэрэгжүүлэхэд оршиж байгаа юм.

Энэ хуульд зааснаар, хэрэв аливаа этгээд дараах санхүүгийн гүйлгээ, мөн төлнөлөн төлбөрийн баримтыг илгээх, шилжүүлэх, зөв үрлэх ажиллагааг хэрэгжүүлсэн бол "мөнгө угаасан" гэж тооцогдоно:

> зээл мөнгөний баримт бичгийг нэг улсаас нөгөө улсад хууль бусаар зөв үрлэсэн буюу тийм хууль бус үйл ажиллагаанд зориуд санаатайгаар дэмжлэг үзүүлсэн.

> тухайн баримт бичиг нь хууль бусаар олсон орлогыг баталж байгааг мэдэж байсан.

> тухайн гүйлгээ нь орлогын эх мөсвэр, байгаа газар, жинхэнэ шинж чанар болон түүнийг эзэмшилт, захиран зарцуулалтыг нуун далдлах буюу нуун дарах зорилготой гэдгийг мэдэж байсан.

Хуульд зааснаар банк нь 5 мянган доллараас илүү (үнэт цаасны хувьд 3 мянган долларын) үнийн дүн бөхий сэжигтэртэй рүү олсон бөх хэлцлийн талаар хуулийн байгууллагад мэдэгдэх үүрэгтэй байдаг.

Сангийн яамны зохих зөвлөмжөөр хэлцлийн болон банкны албан хаагчийн үйл ажиллагааны горимд илрэх “сэжигтэй байдал”-ын шинж тэмдгийг нарийн тодорхойлж үгсн байдаг. Зайлшгүй байх нэг шаардлага бол банкны байгууллага нэг бүрийн дэргэд мөнгө угаахтай тэмцэх тусгай хяналт бүртэй байхыг шаардана.

Тус бүр нь гурван мянган ам.долларын үнийн дүнгээс дээш банкны чек, шуудангийн шилжүүлэг болон чектэй холбоотой байнга дахин давтагдсан хэлцэл, мөн чекээр олон дахин давтах байдлаар (cash - back transactions), бэлэн мөнгө болгосон гүйлгээнд онцгой хяналт тавигдана.

АНУ-ын бөх банк нь бүрийн үйлчлүүлэгчдийн санхүүгийн сэжигтэй үйлдлийн тухай тайлан мэдээг Холбооны Мөрдөн байцаах Товчоонд байнга гаргаж үгх үүрэг хүлээдэг.

Санхүүгийн хүрээний бөхий төлөөлөгчид эрх зүйн ийм үүргийг бүрэн дэмжихгүй нь ойлгомжтой. Гэвч практикаас харахад тухайн хуулийн үйлчлэлийн үр нөлөөтэй байдал нь санхүүгийн үйл ажиллагааг бөх түвшинд хэрэгжүүлж байгаа банкны ажилтнуудын хариуцлагыг эрс дээшлүүлсэн гэж хэлж болно.

Үйлчлүүлэгчдийг дараах мөнгөн хөрөнгөтэй холбоотойгоор явуулж байгаа үйл ажиллагаагаар илрүүлж болно:

> эх сурвалж нь тэдгээрийн гарал үүслийг нууж хаах зорилготой үйл ажиллагааны хууль бус төрөл байх;

> хуулийн шаардлагыг тойрон гарах зорилготой;

> үйлчлүүлэгчийн хувьд түүний ердийн арилжааны практикаас гараагүй, хэвийн бус төрөл байх зэрэг.

1996 оны 04 сарын 1-нээс эхлэн банкууд нь Сангийн яаманд 5 мянган доллараас илүү үнэ бөхий валютын конверситэй холбоотой гүйлгээний тухай мэдээ агуулсан тусгай маягтыг (suspicious activity report) бүгдлэн үгх болжээ. Сангийн яаманд сар бүр мөн валютын эргэлтэд гадаадын гэрээлэгчидтэй нэг сард хийсэн 2 сая доллараас давсан гүйлгээний тухай мэдээлэх үүрэгтэй бол харин экспортлогч, импортлогчид болон бусад банк бус санхүүгийн байгууллага нь нэг улиралд 10 сая доллараас давсан эргэлтийн тухай мэдээллийг улирал бүр сангийн яаманд гаргаж үгнэ. Эдгээр мэдээлэлд үндэслэн сангийн яам нь улсын хэмжээний долоо хоног, сар, улирлын валютын байдлын тухай тайлан гаргана

Дээрхи дүрэм журмыг зөрчсөн тохиолдолд их хэмжээний торгууль төлөх, ажлаас нь халах, эсхүл зориуд санаатайгаар үйлдсэн нь нотлогдвол мөнгө угаасан хэрэгт хамтран ажилласны төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэх зэрэг шийтгэл ногдуулна.

Мөнгө угаахын эсрэг хуулиар санхүүгийн урсгалын хяналт үйлдүүнд хувь хүмүүсийн дансаар дамжуулан хяналтын хатуу хүрээг тогтоосон байдаг. Календарын нэг сарын хугацаанд 10 мянган доллараас давсан үнийн дүн бөхий бэлэн мөнгийг

дансанд хийх, 100 мянган доллараас давсан нэг бөхий бэлэн бус мөнгийг дансаар дамжуулах фактуудыг Холбооны Мөрдөн байцаах Товчоо. Дотоод орлогын албанд нэн даруй, заавал мэдэгдэх ёстой. 10 мянгаас дээш долларыг данснаас авч байгаа этгээд нь энэ мөнгийг авах хангалттай гүндэслэл байгаагаа нотолж байж авах ёвчирэгтэй. Хэрэв энэ этгээд нь бөхийн хэрэгцээгээ гүнэмшилтэйгээр нотолж чадахгүй буюу тайлбарлахыг хүсэхгүй байгаа бол энэ нь мөнгө угаахад хамтран оролцсон шууд бус нотлох баримт гэж нэлэгдэнэ.

Америкийн иргэд нь засаглалын байгууллагын шаардлагаар бөхийн гадаад улс дахь актив, пассив болон гадаад гүнт цаасны гүйлгээний тухай мэдээллийг гаргаж өгөх ёвчирэг хүлээнэ. Энэ шаардлагыг биелүүлэхгүй бол иргэний (2,5 мянган доллараас 10 мянган доллар хүртэл торгох) болон эрмөгийн хариуцлага (10 мянган доллар хүртэл торгох ба/буюу нэг жил хүртэл хугацаагаар шоронд хорих) хүлээнэ.

Америк улсад амьдарч байгаа гадаад улсын банканд данстай хүмүүс нь тийм данс байгаа тухай мэдээг жил бүр гаргаж өгөх, хэрэв иргэн нь хилийн гадна 25-аас илүү данстай бол Сангийн яамны шаардлагаар данс нэг бөхийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл гаргаж өгөх ёвчирэгтэй.

2001 оны 09 сарын 11-ний өйл явдлын дараа АНУ нь гадаадын оюутнуудын хүлээн авч байгаа мөнгөний эх сурвалжийг нухацтай сонирхож эхэлсэн байна. Америкийн 200 орчим коллеж суралцагчдын (тэдний нэрийг дурдахгүйгээр) санхүүгийн баримт бичгийн тухай мэдээллийг ХМБТ болон цагаачлалын албанд гаргаж өгсөн байна. Эдгээр мэдээллийн дотор банкны дансны байдал ба зээлийн картын дугаар зэрэг нууцлалтай холбоотой мэдээлэлүүд багтжээ.

Ийм учраас хувь хүн болон хуулийн этгээдийн дансан дахь ихээхэн хэмжээний мөнгөн хөрөнгийн ямар ч хүдлөгч нь заавал биелүүлэх журмын дагуу, төрийн албаны зохих сонирхогч байгууллагад гаргаж өгсөн ямар нэгэн баримт бичигт бэхжигдэнэ. АНУ-д банкны өйл ажиллагаа хүгжихийн хэрээр иргэд болон банкны захиргаанаас бүлэг, бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай баримт бичгийн жагсаалт тэр хэмжээгээр нэмэгдэж байна.

Итали улс зээлийн байгууллагуудаар дамжин өнгөрч байгаа санхүүгийн урсгалд тавих төрийн хяналтын олон салбарт тогтолцоотой. 1990 оноос эхлэн төрөөс гэмт орлогыг ил болгох оролдлогыг илрүүлэх, таслан зогсоох мониторинг албан журмаар хийх болсон юм. Мониторингийн тогтолцоо нь гадаадад илгээгдэж байгаа мөнгөний ямарч шилжүүлгийг орлогын нэг удаагийн мэдүүлэг заавал дагалдах журмыг тогтоож өгчээ.

1990 онд баталсан Гамм-Вассал хуулиар “мөнгө угаах” гүйлгээ болон 20 сая лир давсан нэг бөхий шилжүүлгийн төлөө эрмөгийн хариуцлага тогтоосон байна. 1991 оны тавдугаар сарын 3-ны өдрийн 143 хуульд зааснаар 20 сая лирээс илүү нэг бөхий шилжүүлэг нь зөвхөн өйлчлүүлэгчийг бүртгэх, адилтгах өйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа бүрэн эрхт зуучлалын агентлагаар дамжуулан зөвшөөрөгдөнө. Гүйлгээний тухай болон хэний мөнөөс тухайн гүйлгээг хийж байгаагаа мэдэгдэхээс татгалзсан, эсхүл худал мэдээлсэн этгээдэд 6 сар хүртэл хугацаагаар хорих буюу 1 саяаас 10 сая лир хүртэл торгох шийтгэл хүлээлгэнэ.

Дээр дурдсан хуульд банкны системн байгууллагуудаас 20 сая лирээс илүү шилжүүлэг нэг бөхийн тухай эрх бөхий байгууллагад заавал мэдэгдэх механизмыг нарийн тодорхойлсон байдаг.

Мөн санхүүгийн хяналтын байгууллагад, хувь хэний тухай, төний нийгмийн байдал, валютын дансны хаяг, мөнгөн хөрөнгийг шилжүүлэг хэний нэр дээр хийгдсэн, гүйлгээ хийгдсэн хугацаа, гүйлгээ хийгдэхийн өмнө ба хойно валютын дансны мөнгөний тоо зэргийг танилцагдах ёстой. Банкад мэдээлэл хадгалагдах хугацаа 5-10 жил байдаг.

Иймэрхүү гүйлгээний тухай сангийн сайдад мэдэгдэх (84.11.24-дрийн ¹ 689 хууль) механизм байдаг. Бэрэн эрхт зуучлагчийн хувьд эрхийн, мөн захиргаа, санхүүгийн хариуцлагыг хангалттай тогтоож өгсөн байна. Банк болон бусад зуучлалын байгууллагууд нь мөнгө “угаах” магадлалтай оролдлогын тухай хуулийн байгууллагуудад цаг алдахгүй мэдээлэхийн тулд гадаадын иргэдээс явуулж байгаа валютын гүйлгээний талаар дэлгэрэнгүй баримтжуулах үүрэгтэй.

Италийн хуулийн байгууллагууд, эхний ээлжинд Санхүүгийн гвардын санаачлагаар мөнгөний урсгалын хөдөлгөөнийг баримжаалах, санхүүгийн хууль бус гүйлгээний оролцогчдыг илрүүлэх чадвартай тогтолцоог бүрдүүлэхээр ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд нэг талаас Төв банк ба зээлийн бэхийн институтын тогтолцооны, нөгөө талаас Төв банк ба Санхүүгийн гвардын компьютерын мэдээллийн тогтолцооны хооронд харилцаа холбооны сүлжээ ажиллаж эхлээд байна. Өөний өрдөнд Төв банк нь зээлийн бэтцүүд болон санхүүгийн цагдаагийн хооронд зуучлагчийн үүрэг гүйцэтгэж байна.

Олон улсын шинжээчдийн дүгнэлтээр, италийн хууль тогтоомж нь гэмт хөрөнгийг “угаах”-аас урьдчилан сэргийлэх талаар хамгийн өрнөлтөйд тооцогдсон учраас валютын хяналт болон валютын эргэлтийн салбарын өндэсний хууль тогтоомжийг ижилтгэх (унификаци) загвар болгохыг Европын холбооноос зөвлөмж болгосон юм.

Италийн өндэсний хууль тогтоомжоор, явагдаж байгааг гүйлгээг гэмт явдлын зэрэглэлд хамааруулах боломжийг гэрчилж байгаа 150 орчим шинжийг тодорхойлсон байна. Банкнаас иймэрхүү гүйлгээний тухай мэдээллийг цааш нь шалгуулахаар Валютын тусгай товчоонд шилжүүлж байна. Гэмт ажиллагааг хэрэгжүүлэх оролдлогын тухай сэжиг нотлогдсон тохиолдолд тухайн мэдээллийг нь Дотоод хэргийн яамны мафитай тэмцэх талаарх мөрдөн байцаах департамент болон Санхүүгийн гвардын валютын цагдаагийн албанд мөрдөн байцаах, шуурхай эрэн сурвалжлах арга хэмжээг авч хэрэгжүүлэх зорилгоор шилжүүлнэ.

Италийн эрхийн хуулиар гэмт хэргийн замаар олсон эд хөрөнгө, орлогыг ил болгох үйл ажиллагаа эрхэлсэн этгээдийн хувьд 7-12 жил хорих болон 2-30 сая лирээр торгох ял шийтгэлийг ногдуулна. Хэрэв энэ үйлдлийг албан тушаалтан өөрийн албан өргийн байдлаа ашиглан үйлдсэн бол илүү хатуу ял ногдуулна.

Бельги улсад санхүүгийн институциар дамжин өнгөрч байгаа санхүүгийн урсгалд тавих хяналтыг хичтэй болгох зорилгоор Хааны 1993 оны зургадугаар сарын 11-ний зарлигаар хууль зүйн болон сангийн яамны дунд “Санхүүгийн мэдээллийг боловсруулах сектор” (CTIF) гэсэн тусгай нэгжийг байгуулжээ. Энэ байгууллага нь зохих шинжээчдийг татан оролцуулах замаар банк, бирж болон санхүүгийн бусад институциудын сэжигтэй гүйлгэний тухай мэдүүлэгт задлан шинжилгээ хийж, цагдаа, гааль болон төрийн бусад байгууллагуудын мэдээллийг ашиглаж байна.

Шаардлагатай тохиолдолд энэ байгууллага мэдээллийг шалгах зорилгоор санхүүгийн сэжигтэй гүйлгээг 24 цагийн дотор зогсоох эрхтэй. Мөн төний зэрэгцээ

түүний ажилтнууд нь мөрдөн байцаах ял ажиллагааг бие даан явуулахгүй. “Бохир” мөнгийг “угааж” байгаа тухай мэдээлэл нотлогдсон тохиолдолд СТIF нь зохих материалыг Брюсселийн шилжүүлэх бөгөөд, прокурор нь эхний ээлжинд холбооны цагдаагийн тусгай салбартай хамтран шуурхай эрэн сурвалжлах, мөрдөн байцаах ажиллагааг явуулж, эрүүгийн хэрэг үүсгэнэ.

10 мянган ЭКЮ-гээс дээш үнэ бүхий бүх хэлцлийг заавал шалгаж, санхүүгийн гүйлгээний тухай бүхий л мэдээллийг 5-аас доошгүй жил хадгална. Хууль зөрчсөн тохиолдолд тухайлбал, 50 сая белгийн франк хэртэл торгох зэрэг нилээд ноцтой санкци хэрэглэнэ.

Зохих хууль тогтоомжийн зөрчлийг илрүүлэх, валютын контрбанд ба хөрөнгө “угаах”-ыг таслан зогсоох зорилт нь эрүүгийн цагдаагийн ерөнхий комиссарын удирдлаган дор 1993 оны арван нэгдүгээр сараас ял ажиллагаагаа явуулж эхэлсэн, тусгай салбар-Эдийн засгийн ба санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх төв товчооны чиглэл рэгт хамаарч байгаа юм.

Их Британид гэмт хөрөнгө “угаах”-ыг таслан зогсоох ял ажиллагааг зохицуулахын тулд эрүүгийн бүрэлдэхүүнд эдийн засгийн санхүүгийн секторын тэргүүлэх зүтгэлтнүүдийг багтаасан Ажлын нэгдсэн тусгай хэсгийг байгуулсан байна. Шуурхай эрэн сурвалжлах ажлыг Санхүүгийн хэргийг мөрдөн шалгах Их Британийн үндэсний алба эрхлэх бөгөөд түүний бүрэлдэхүүнд Валютын хэргийг мөрдөн шалгах товчоо багтана.

Энэ салбарт хамааралтай хэм хэмжээний үндсэн баримт бичгүүдэд: Мөнгө угаахтай тэмцэх талаарх санхүүгийн нэгжүүдийн удирдлагын дүрэм; Их Британийн эрүүгийн хууль; 1993 онд баталсан Хөрөнгийг “угаах”-тай тэмцэх талаарх удирдамж зэргийг дурдаж болно. Эдгээр баримт бичгүүдэд хөрөнгө “угаах”-тай тэмцэх талаарх Европын Холбооны Удирдамжийн зөвлөмж, шаардлагуудыг тусгасан байна.

Хэрэв мөнгөн хөрөнгийг эрүүгийн ноцтой гэмт хэргийн орлого гэдгийг мэдсэн буюу сэжиглэсэн этгээдээс ямар нэгэн этгээдэд мөнгө “угаах”-ад нуух, хадгалах буюу хөрөнгө оруулах замаар хамтран ажилласан хувь хүний гүйлдлийг гэмт хэрэг гэж тооцно. Мөнгө угаасан этгээдийг 14 жил хэртэл хорих; мэдээллийг гэмт хэрэгтэнд буюу гуравдагч этгээдэд задруулсан бол 5 жил хэртэл хорих; мөнгө “угааж” байгааг мэдсээр байж энэ тухай мэдэгдээгүй этгээдэд 5 жил хэртэл хорих ялаар шийтгэнэ.

Мөн хууль бусаар олж авсан хөрөнгийг хууль бусаар ил болгох боломж олгосон санхүүгийн байгууллагын эс үйлдэхгүй нь эрүүгийн гэмт хэрэгт тооцогдоно.

Британийн валютын болон банкны ерөнхийд нь нилээд аядуу дэглэм нь дээр дурдсан зарим баримт бичгүүдэд заагдсанд үл хамаарах зарим зүйлийг агуулна. 1994 оны дөрөвдүгээр сарын 1-нээс эхлэн 15 сая ЭКЮ (12 мянган доллар) давсан хэлцэлд бол үйлчлүүлэгчийг танин олох дүрэм журам үйлчилнэ.

Олон улсын экспертүүдийн үзэж байгаагаар, британийн валют болон экспортын хяналтын хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийг ФАЭФ болон ЕХ-ноос боловсруулж, зохицуулж байгаа, хууль бусаар олсон хөрөнгийг “угаах”-тай тэмцэх арга хэмжээ, зөвлөмжийг илүү гүнзгий тусгах байдлаар боловсронгуй болгох шаардлагатай байгаа юм.

Зээлийн байгууллага болон хуулийн байгууллагуудын мэдээллийн харилцан ажиллагааны зохицуулалтын хувьд хамгийн зөвлөлдөх хууль бол Германы хууль тогтоомж орно.

Энд зээлийн институциуд нь холбооны засаглалд “бохир” мөнгийг ил болгосон зөвхөн илэрхий шинж тэмдэг байгаа тохиолдолд л шаардлагатай мэдээллийг өгөх ёстой. Тэгсэн хэдий ч хэлцлийн төд өйлчлөллэгчийг таньж тодорхойлох, төлчлэн тодорхой хугацаанд эдгээр мэдээллийг хадгалах тухай заавал мөрдөх л зохих журам өйлчилнэ.

Норвегийн төндөсний банкинд мөнгөний олон улсын сая ил шилжлэг цахим санамжид бүртгэгдэж, хадгалагдах ба энд мэдээлэл дөрвөн жилийн хугацаанд хадгалагдана. Цагдаа болон гаалийн байгууллага нь бөх орны банкны тогтолцоог ашиглаж байгаа этгээд төдийн тухай бөхий л мэдээллийг агуулж байгаа архивыг дуртай цагтаа ашиглах боломжтой.

1997 оны нэгдүгээр сарын 1-нээс 3400 ам доллараас давсан мөнгийг илгээсэн, 5400 ам доллар хөлээн авсан мөнгөний шилжлэг нь хяналтад хамаарах хэлцэлд тооцогдож, төлний төний дүн нь автоматаар бэхжигдэнэ. Зарим эзлэг шалгалтын дараа төлний зарим хэсэг нь банкнаас цагдаад мэдэгдсэний дагуу мөнгө угаах оролдлого гэж төнөлөгдөнэ.

Латин америкийн зарим улсад ФАТФ-ын зөвлөмжийн дагуу мөнгө угаахад тавих хянах зорилгоор, өөр өөр хэлбэл мөнгө “угаах”-аас урьдчилан сэргийлэх арга хэрэгсэл, хэрэв мөнгө угаагдсан тохиолдолд төнд өр нөхлөтэйгээр сөрөг өйлчлэлтийг хангахын тулд санхүүгийн тогтолцооны цэвэр тунгалаг байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр төрийн хуулиудын загварыг боловсруулсан юм. Томоохон хэмжээний хэлцлөдийн тухай мэдээллийн төв агентлагт мэдээлэх өөрөг энэ бөс нутгийн зөвхөн нэг хэсэгт л байдаг бол нөгөө нэг хэсэг нь тодорхой дөрөм журмаас гадуур бэлэн мөнгөөр хийх томоохон хэлцлөдийг шууд хориглодог байна. Ихэнх улс оронд мөнгө угаахтай тэмцэх тусгай агентлаг ажилладаг байна.

Дүгнэлт

Гадаад улс орны хууль эрх зүйн байгууллага болон банк санхүүгийн байгууллагын хамтын ажиллагааны туршлагаас эзэхэд банкны холбогдох мэдээлэлд өрсөлдөгч байгууллага болон гэмт бөлөглөлдөдийг гарт очихгүй байх баталгааг дээд зэргээр хангасан механизмыг бүрдүүлэхийг хичээдэг байна.

Эрх бөхий байгууллагын ажилтнуудын хуульд заасан банкны, албаны, арилжааны болон татварын нууцыг бүрдүүлж байгаа тухайн байгууллагын өйл ажиллагаатай холбоотойгоор тэдэнд илэрхий болсон мэдээллөдийн хадгалах хамгаалах өөрөг нь хамтын хариуцлагын нарийн механизм дутагдсан, тунхаглалын шинжтэй болсон зохих төвшинд шаардлага хангаж ажиллаж байна чадахгүй байна гэж дүгнэдэг байна.

Эдгээр бөх нөхцөл байдлуудаас манай улсын банкны хууль тогтоомж, санхүүгийн тогтолцоо нь улс орны хөгжлийн нэн чухал асуудал тул хууль, санхүүгийн хяналтын байгууллагууд болон банкны байгууллагуудын мэдээллийн хамтын ажиллагааг дээрхи туршлагаас анхаарч зохион байгуулах шаардлагатай байгаа юм. Энэхүү харилцан ажиллагааны механизмуудыг эрх зүйн хэм хэмжээнд аль хэр нарийн тодорхой хуульчлах эсэхээс эцсийн дүнд Монгол улсын банкны тогтолцооны өйл ажиллагаа ил өр нөхлөтэй, иргэнлэг болох учиртай.

Энэ байдлаас харахад дэлхий дахинд банк зээлийн байгууллагуудаар дамжин мөнгөрч байгаа санхүүгийн урсгалын хөдөлгөөнд тавих төрийн хяналтыг улам чангатгах хандлага ил өндөр хөгжиж байна. Баруун европ болон хойт америкийн орнуудаар

хязгаарлахгүй, дэлхийн бараг бүх улс орнууд уйлчлүүлэгчдийг адилтгах, валютын томоохон хэлцлүүдийг нөхөн сэргээх зорилгоор тоо бүртгэл хтлэх, сэжигтэй хэлцлийн тухай мэдээлэх ийин эрх зйн хамгаалалтын талаарх ФАТФ-ын зарчмуудыг хлээн авч хэрэгжлж байна.

Дээр дурдагдсан хяналтын хрээнд манай улсад банк зээлийн байгууллагуудаас трийн санхүүгийн болон хуулийн байгууллагуудад заавал гаргаж гх мэдээллийн багтаамжыг улам нарийвчлалтай нэмэгдлэх, “Мнг угаах, санхүүгийн гэмт хэргийг мрдн шалгах ажлын хэсэг”-ийг байгуулж, мэдээлэлх рэг бхий этгээддээс Санхүүгийн мэдээллийн албанд ирдэг гйлгээний талаарх мэдээ, мэдээлэл дээр ажлуулах тусгай журам батлан мрдх зэрэг хууль эрх зйн орчинг брдллх шаардлагатай гэсэн саналтай байна.

Эх сурвалжийн жагсаалт

- Монгол Улсын ндсэн хууль. Трийн мэдээлэл. 1992.
- Мнг угаах болон терроризмыг санхүүжлхтэй тэмцэх тухай хууль. трийн мэдээлэл. 2006.
- Монгол Улсын Эрлийн хууль. Трийн мэдээлэл. 2002.
- Авилгын эсрэг хууль. 2006.
- Мнг угаах угаах болон терроризмыг санхүүжлхтэй тэмцэх ндэсний хтлб р Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 143 тогтоол.
- ФАТФ-ын звлмжийн техникийн хэрэгжилтийг нэлэх болон мнг угаах, терроризмыг санхүүжлхтэй холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцооны рднтэй байдлыг дгнэх аргачлал. 2013
- “Мнг угаах, терроризмыг санхүүжлхтэй холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх” сэдэвт СЭЗЯ, Монгол банкны хамтарсан семинар, УБ, 2004
- Право. Международная конференция ЗОтмывания денег и выявление доходов от преступной деятельности” М.1997.
- В.А.Никулин. Отмывание Трязных денег” уголовно-правовая характеристика и проблемы соучастия. 2001.
- Уголовный кодекс зарубежных стран /США, Германия, Англия, Норевгия/ М.2007.